



## ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

**Байгууллагын нэр:** Санхүү Эдийн Засгийн Их Сургууль

**Хөтөлбөрийн нэр:** “Бизнес удирдлага” докторын хөтөлбөр

**Индекс:** 041301 доктор

**Шинжээчийн баг:**

Ахлагч: Н.БАТНАСАН

Гишүүд: Л.ЭНХ-АМГАЛАН

О.БУРМАА

С.ӨЛЗИЙСАЙХАН

Улаанбаатар хот

2023 он

## **Агуулга**

### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур1: Докторын хөтөлбөрийн зорилго, агуулга

Шалгуур 2: Докторын хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт

Шалгуур 3: Докторантын суралцахуйн үнэлгээ, хөгжил

Шалгуур 4: Багшлах бүрэлдэхүүн

Шалгуур 5: Нөөц ба санхүүжилт

Шалгуур 6: Удирдлага ба мэдээллийн систем

Шалгуур 7: Чанарын баталгаажуулалт

### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Санхүү Эдийн Засгийн Их Сургууль The University of Finance & Economics	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Бизнес удирдлага Business Administration	
<b>Индекс</b>	041301	
<b>Шинжээчид</b>	Ахлагч: Н.Батнасан, МУИС-ийн Бизнесийн сургуулийн захирал, профессор, доктор Гишүүд: Л.Энх-амгалан, Мандах их сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, профессор, доктор О.Бурмаа, ОУУБИС-ийн Бизнес удирдлагын тэнхимийн профессор, доктор С.Өлзийсайхан, ХИС-ийн харъяа “Билиг” дээд сургуулийн захирал, профессор, доктор	
<b>БМИҮЗ-ийн зохицуулагч</b>	С.Бадамцэцэг, БМИҮЗ-ийн ажлын албаны Магадлан итгэмжлэл хариуцсан ахлах мэргэжилтэн	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b> /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2023.05.24	БМИҮЗ-ийн ажлын албатай Шинжээчээр ажиллах гэрээ байгуулж, өөрийн үнэлгээний тайланг хүлээн авсан.
	2023.06.02	Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайланг Ажлын албанд илгээсэн.
	2023.06.7-8	Сургууль дээр ажилласан.
	2023.06.16	Шинжээчийн үнэлгээний тайланг Ажлын албанд илгээсэн.
	2023.06.19	Сургуулийн саналтай танилцаж, тайланг эцэслэв.
	2023.06.22	Бизнес, удирдлага, эрх зүй чиглэлийн МЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэв.
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 06 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Докторын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шалгуур, шаардлага”	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

СЭЗДС-ийн Захирлын 2009 оны 05-р сарын 06-ны өдрийн “СЭЗДС-д докторын хөтөлбөр нээх тухай” 85 тоот тушаал гарснаар тус сургуульд эдийн засаг, бизнес, менежментийн өндөр мэдлэгтэй судлаач бэлтгэх зорилго бүхий докторын сургалтыг явуулж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх, докторын сургалтыг хариуцан зохион байгуулах функциональ чиг үүрэг бүхий “Эрдэм шинжилгээ, судалгаа, докторантурын алба”-ыг СЭЗДС-ийн Захирлын тушаалаар байгуулжээ Мөн “СЭЗДС-ийн Докторын сургалт явуулах журам”-ыг СЭЗДС-ийн захирлын 2010 оны 02 сарын 25-ны өдрийн 044 тоот тушаалаар батлуулж, мөрдөж ажилласан ба уг тушаалыг 2015 онд шинэчлэсэн. Боловсролын салбарт гарч буй шинэчлэл сургалт, судалгааны үйл явцад хийсэн дүн шинжилгээнд үндэслэн “Докторын сургалтын журам”-ыг СЭЗИС-ийн Ректорын 2020 оны 09 сарын 28-ны өдрийн А/214 тоот тушаалаар дахин шинэчлэн боловсруулж, докторын сургалтын үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.

Докторын хөтөлбөрийн эрхэм зорилгоо шинжлэх ухааны олон талт мэдлэгийг суралцагчдад олгож, мэргэжлийн өндөр түвшинд манлайлан ажиллаж, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрдэм шинжилгээ, судалгаа хийх, удирдах болон бодлогын түвшний шийдвэр гаргах ажил үүргийг гүйцэтгэх мэдлэг, чадвартай мэргэжилтнийг бэлтгэж, судалгаа, сургалтын төгөлдөршлийг хангана гэж тодорхойлсон.

Докторын хөтөлбөрийн хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг Асуудлыг тодорхойлох (PLO-1), Судалгааны дизайн боловсруулах (PLO-2), Задлан шинжлэх (PLO-3), Үнэлэн дүгнэх (PLO-4), Гарц шийдэл олгох (PLO-5), Ёс зүйг баримтлах (PLO-6), Илэрхийлэх чадвар (PLO-7) гэж тодорхойлсон.

“Бизнесийн удирдлага” докторын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө нь БСШУСайдын А/370, Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журмын 2.3.2-ын шаардлага, СЭЗИС-ийн Ректорын 2022 оны 01 сарын 11 өдрийн А/06 тушаалын 2 дугаар хавсралтаар “Докторын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний стандарт”-д тус тус нийцүүлэн сургалтын төлөвлөгөөний бүтцийг дараах байдлаар тодорхойлсон.

### Сургалтын төлөвлөгөөний бүтэц

Хичээлүүд	Заавал судлах	Сонгон судлах	Нийт	Эзлэх хувь
Судалгааны арга зүйн хичээлүүд	15		15	25%
Мэргэжлийн хичээлүүд	6	Нэмэлт хичээлээр	6	10%
Мэргэшүүлэх хичээлүүд	15		15	25%
Төгсөлтийн ажил	24		24	40%
	60		60	100%

## III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

## Шалгуур 1. ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, АГУУЛГА

Үндэсний хөгжлийн стратеги, сургуулийн судалгаа ба хөгжлийн стратеги, мэргэжлийн салбарын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан оролцогч талуудын эрэлт хэрэгцээг тусган хөтөлбөрийн зорилго, агуулгыг шинэчлэн, хөтөлбөрийн чанарыг байнга сайжруулдаг байна.

### 1.1. Хөтөлбөрийн боловсруулалт

Дээд боловсролын хууль эрх зүй, докторын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, хэрэглэгч ба оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулж, хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор жил бүр хянан үнэлдэг байна. Докторантын гүйцэтгэх судалгаа, хөгжил, бүтээлч ажлууд нь хөтөлбөрт дийлэнх хувийг эзлэх ба тэдгээрийн төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, чанарын баталгаажуулалт, үр дүнг хүлээн зөвшөөрөх арга барил нь хувь хүний болон мэргэжлийн хөгжлийг дэмжин, чанартай судалгаа хийхэд чиглэсэн чөлөөт сонголт бүхий олон хувилбартай хэрэгждэг байна.

#### Илрэл нотолгоо:

- СЭЗИС-ийн Ректорын 2020 оны А/214 тоот тушаалаар баталсан “Докторын сургалтын журам”
- Бизнесийн удирдлагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд зориулсан өөрийн үнэлгээний тайлан
- Бизнесийн удирдлагын докторын сургалтын төлөвлөгөө

#### Онцлог зүйл:

- СЭЗИС нь докторын хөтөлбөрөө БШУС-ын А/370 тоот тушаалаар баталсан “Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах журам”-д нийцүүлэн боловсруулсан байна.
- СЭЗИС нь “Бизнесийн удирдлага” докторын хөтөлбөрөө 2014, 2016, 2017, 2020, 2022 онд шинэчлэн сайжруулсан. Хөтөлбөрийн шинэчлэлдээ анхаарч, хөтөлбөрөө сайжруулах тал дээр байнга анхааран ажиллаж байгаа нь сайшаалтай.
- 2022-2023 оны хичээлийн жилд хөтөлбөрийн STEEP шинжилгээг хийж, докторын хөтөлбөрөө хэрэгжүүлж буй орчин, нөхцөлдөө ул суурьтай шинжилгээг хийсэн. Сургалтын нөхцөл байдлаа шинжлэн судалсны үндсэн хөтөлбөрүүдээ шинэчлэн сайжруулах хэрэгцээ шаардлагаа тодорхойлсон нь сайшаалтай.
- Докторын хөтөлбөрөө амжилттай хэрэгжүүлэхийн тулд хөтөлбөрийг байгуулсан цагаасаа эхлэн бусад их сургуулиудтай нягт хамтран ажиллаж ирсэн. СЭЗИС-ийн олон докторантын судалгааны ажлыг бусад их дээд сургуулиудын мэргэжлийн багш нар удирдсан буюу удирдаж байгаа.
- Докторын хөтөлбөрийг анх хэрэгжүүлж эхэлсэн 2009 оноос хойшхи богинохон хугацааны дотор түүнийг өрсөлдөх түвшний хөтөлбөр болгон хөгжүүлж чадсан нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж, хэрэгжүүлж ирсэн баг, хамт олны хичээл зүтгэлтэй шууд холбоотой.

#### Анхаарах асуудал:

- Олон улсад өрсөлдөх түвшний, мэдлэг бүтээх чадвартай судлаачийг сургаж бэлтгэх асуудлыг докторын хөтөлбөрийг боловсруулахдаа гол чиг баримжаагаа болгох ёстой. Гэвч хөтөлбөрт багшилж буй багш нар, суралцаж буй оюутны, мөн багш оюутны хамтарч олон улсын өндөр түвшний сэтгүүлд бичсэн өгүүллийн тоо цөөн, судалгаа шинжилгээний ажлаас олж буй орлогын хэмжээ бага байна. Энэ нь хөтөлбөрт судалгаа шинжилгээний тал дээрээ илүүтэй анхаарсан өөрчлөлт хийх шаардлагатайг харуулж байна.
- Докторын хөтөлбөр нь массын бус, цөөн тооны чадварлаг судлаач нарыг сургаж бэлтгэдэг хөтөлбөр тул аль ч сургуульд эдийн засгийн хувьд үр ашиггүй. Гэвч докторын хөтөлбөр нь их сургуулийн нэр хүнд, олон улсын түвшний судалгааг авч явдаг хамгийн чухал хэсэг нь юм. Тиймээс хөтөлбөрийг боловсруулахдаа эдийн засгийн үр ашгийг харахаасаа илүүтэйгээр докторын оюутан өөрт шаардлагатай мэдлэг, чадварыг олж авахуйц сонголтыг бий болгох талыг харгалзах нь илүү чухал юм.

### **Дүнэлт:**

- СЭЗИС-ийн докторын хөтөлбөр нь БШУ-ны Сайдын А/370 тоот тушаалаар баталсан “Магистр, докторын хөтөлбөр эрхлэхэд баримтлах нийтлэг журам”-д нийцүүлэн сургалтын хөтөлбөрөө боловсруулсан.
- Докторын хөтөлбөрөө цаашид хөтөлбөрийн гол зорилго болох шинэ мэдлэг бүтээх, ялангуяа олон улсын түвшний бүтээлүүдийг бий болгох чадвартай судлаачийг бэлтгэх тал руу чиглүүлэн хөгжүүлэхэд анхаарах шаардлагатай. Үүний тулд хөтөлбөрийн эдийн засгийн үр ашгаас илүүтэйгээр докторын оюутанд өөрт нь шаардлагатай мэдлэг, ур чадварыг олж авахуйц сонголтыг бий болгох тал дээр анхаарч, хичээл сонголтын боломжийг өргөжүүлэх нь зүйтэй.

### **Үнэлгээ:** Хэсэгчлэн хангасан

### **Зөвлөмж:**

- Докторын хөтөлбөр бол сургалтаас илүүтэй, судалгаа руу чиглэсэн хөтөлбөр. Мэдлэг бүтээх чадвартай судлаачийг бэлтгэх нь гол зорилго. Сонгон авсан чиглэлээр судалгааны ажлаа хийхэд дутагдаж буй мэдлэг, чадварыг олж авахад шаардлагатай олон төрлийн хичээл, сонголтын өргөн боломжийг бий болгох нь энэ түвшний сургалтын хөтөлбөрт чухал байдаг.
- Хичээл сонголтыг докторын хөтөлбөрийг магистрын хөтөлбөртэй уялдуулах замаар буюу магистр болон докторын түвшинд аль алинд нь үзэх боломжтой хичээлүүдийг бий болгох замаар өргөжүүлэх боломжтой. Энэ нь магистрын хөтөлбөрөөс докторын хөтөлбөрт суралцах эрэлтэд бас эерэг нөлөөтэй.
- Докторын түвшний судалгааг дэмжих болон санхүүжүүлэхэд зарцуулж буй зардлаа нэмэгдүүлэх, ялангуяа олон улсын түвшний бүтээлүүдийн үнэлгээг сайжруулах, багш оюутны хамтарсан судалгааг дэмжсэн дүрэм журмуудыг боловсруулах замаар олон улсын ранкаа дээшлүүлэх боломж бий.

## **Шаардлага:**

- Шаардлагатай мэдлэг чадварыг олж авахуйц хичээл сонголтыг бий болгох

### **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн төгсгөлд докторантын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал буюу суралцахуйн зорилтот үр дүнгээр хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон байна. Хөтөлбөрийн зорилго нь тухайн шинжлэх ухааны чиглэл, улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн стратеги, сургуулийн судалгааны зорилгод нийцсэн (сургуулийн чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг) байна. Суралцахуйн зорилтот үр дүнг тодорхойлоход оролцогч талуудыг татан оролцуулж, тэдний эрэлт хэрэгцээ, шаардлагыг тусгасан байна.

### **Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-ийн Ректорын 2020 оны А/214 тоот тушаалаар баталсан “Докторын сургалтын журам”
- Бизнесийн удирдлагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд зориулсан өөрийн үнэлгээний тайлан
- Бизнесийн удирдлагын докторын сургалтын төлөвлөгөө

### **Онцлог зүйл:**

- Хөтөлбөрийг боловсруулахдаа улс орны урт хугацааны хөгжлийн бодлого, олон улсын дээд боловсролын хөгжлийн ерөнхий чиг хандлагыг харгалзан үзсэн нь сайшаалтай.
- 2016 онд СЭЗС нь энтрепренёр их сургууль болж хөгжих стратегийн зорилго дэвшүүлсэн. Энэхүү зорилгоо хэрэгжүүлэхийн тулд ШУА, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаа.

### **Анхаарах асуудал:**

- Энтрепренёр хөтөлбөр нь техник технологи, бизнесийн практиктай холбоотой хөгждөг боловч тус сургуульд хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхүйц бүтэц зохион байгуулалт хараахан байхгүй. Тус их сургууль хөтөлбөрийн зорилго зорилтууддаа нийцүүлэн техник, технологид суурилсан сургалт, судалгааны бүтцийг бий болгох тал дээрээ анхаарах нь чухал.

### **Дүгнэлт:**

- Тус их сургууль нь орчин үеийн энтрепренёр их сургууль болон хөгжих стратегийн зорилго дэвшүүлсэн. Ийм чиглэлийн сургалт, судалгааг техник, технологи, бизнесийн практиктай холбож байж сая амжилттай хэрэгжүүлэх боломжтой. Гэвч тус сургуульд энэхүү зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүтэц зохион байгуулалт хараахан бүрдээгүй тул ШУА, бизнесийн байгууллагуудтай ажил хэргийн холбоо тогтоох замаар сургалт, судалгаагаа явуулахыг зорьж ажиллаж байна.

- Тус сургуулийн хувьд алс хэтийн зорилгоо зоримог байдлаар тодорхойлж, түүндээ хүрэхийн тулд үйл ажиллагаагаа үе шаттайгаар зохион байгуулж байгаа нь сайшаалтай.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:**

- Энтрепренёр их сургууль болон хөгжихөд шаардлагатай технологи дамжуулах, оюуны өмчийг хамгаалах, стартап компанийг байгуулах, санхүүжүүлэх дүрэм журмуудаа боловсруулан гаргах нь чухал.
- Энтрепренёр их сургууль болон хөгжихөд шаардлагатай судалгааны дэд бүтцийг хөгжүүлэх, стратегийн зорилгодоо нийцсэн судалгааны чиглэлүүдийг оновчтой тодорхойлон гаргах асуудалд анхаарах шаардлагатай

### **1.3. Хөтөлбөрийн агуулга**

Хөтөлбөрийн агуулга нь шинжлэх ухааны чиглэл, суралцахуйн зорилтот үр дүнд нийцсэн байна. Хөтөлбөрийн агуулга нь мэргэжлийн болон салбар дундын судалгааг хөгжүүлэхэд чиглэх ба онол практикийг зохистой хослуулан, логик дэс дараалалтай, давхардалгүй хэрэгжүүлэх сургалтын болон судалгааны төлөвлөгөөг боловсруулж, заавал болон сонгон суралцах агуулга, сургалтын хэлбэрийг зохистой тогтоож, мөрддөг байна.

**Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-ийн Ректорын 2020 оны А/214 тоот тушаалаар баталсан “Докторын сургалтын журам”
- Бизнесийн удирдлагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд зориулсан өөрийн үнэлгээний тайлан
- Бизнесийн удирдлагын докторын сургалтын төлөвлөгөө

**Онцлог зүйл:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойш харьцангуй богино, 10 гаруйхан жил өнгөрч байгаа боловч хөтөлбөрийн агуулгад хэд хэдэн удаа томоохон өөрчлөлт хийжээ. Энэ нь докторын сургалтыг зохион байгуулах тусгайлсан бүтцийг бий болгосон, зөвхөн докторын хөтөлбөрийг хариуцсан профессоруудыг ажиллуулж эхэлсэн зэрэгтэй нь холбоотой. Ийм бүтэц алсдаа элсэн орсон докторын оюутныг судалгаа шинжилгээний чиглэлд төвлөрөхөд нь тустай байж болох юм.
- Тус сургууль стратегийн зорилгоо ирээдүйд энтрепренёр их сургууль болон хөгжихөөр дэвшүүлсэн нь салбар дундын судалгаанд илүүтэй анхаарна гэсэнтэй агаар нэг юм.
- Докторын сургалтыг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалт, судалгааны дэвшилтэт хэлбэрүүдийг ашиглаж байгаа нь сайшаалтай байна. Жишээ нь: Retreat camp



### **Анхаарах асуудал:**

- Докторын хөтөлбөрийн бакалавр, магистрын хөтөлбөрүүдээс ялгарах гол онцлог нь шинэ мэдлэг бүтээх. Агуулгын хувьд докторын хөтөлбөрөө судалгаа руу илүүтэй чиглүүлэх ёстой гэсэн үг. Гэвч одоогоор докторантын сургалтыг судалгаа руу, тус сургуулийн стратегийн зорилго зорилтуудад нийцсэн судалгаа шинжилгээний чиглэлийг дэмжих, олон улсын ранкыг дээшлүүлэх зэрэгт шууд чиглүүлсэн дүрэм журам, зохицуулалтыг хараахан бий болгож чадаагүй байна.
- Докторын хөтөлбөрт тусгасан хичээл сонголтын агуулга нь суралцаж буй докторант өөрийн хийж буй судалгааны чиглэл, өөрийн судалж буй чиглэлд шаардагдаж буй мэдлэгийг олж авахуйц өргөн хүрээний сонголттойгоор боловсруулагдсан байх ёстой. Одоогоор хөтөлбөрт 11 хичээл үзэж судлахаар тусгасан нь дээрх агуулгын хүрээнд сонголт хийх шаардлагыг хангахгүй юм.

### **Дүгнэлт:**

- Докторын хөтөлбөрийн гол онцлог бол шинэ мэдлэг бүтээх. Тиймээс агуулгын хувьд докторант өөрийн судалгааны ажилд шаардагдаж буй мэдлэгийг олж авахуйц хичээл сонголтыг бий болгох гэсэн асуудалд онцгойлон анхаарах шаардлагатай. Мөн судалгаа шинжилгээний ажлын туршлагатай багш нарын заадаг хичээлүүдийг сонгон судлах боломжийг өргөтгөхөд анхаарах нь чухал.
- Одоогоор тус хөтөлбөр харьцангуй шинэ, эхлээд удаагүй байгаа тул олон улсын хэмжээнд судалгаа шинжилгээний ажил хийх туршлага хуримтлуулсан багшийн тоо, хэвлүүлсэн бүтээлийн тоо цөөхөн байна.

**Үнэлгээ:** Хэсэгчлэн хангасан

### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн агуулгыг олон улсын түвшний судалгааг хөгжүүлэх чиглэлд анхаарч, судалгааг санхүүжүүлэх, докторын оюутан багштайгаа хамтран судалгаа хийхэд чиглүүлсэн дүрэм журмуудыг бий болгох,
- Сургалтын хөтөлбөрт тусгасан хичээлийн агуулга, хичээл сонгох боломжийг докторын оюутны судалгааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өргөжүүлэх

### **Шаардлага:**

- Хөтөлбөртөө докторантын судалгаа шинжилгээний ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн өөрчлөлтүүдийг хийх

#### **1.4. Хичээлийн хөтөлбөрүүд**

Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хичээл бүрийн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулсан байна. Үүнд: тухайн хичээлийг судлах үндэслэл, урьдач нөхцөл, уялдаа холбоо, суралцахуйн зорилтот үр дүн, хичээлийн агуулга, багц цаг,

докторантын суралцахуйн ачаалал, үнэлгээний аргачлал зэргийг дэлгэрэнгүй багтаасан байна. Эдгээрийг байнга сайжруулахын зэрэгцээ тухай бүр суралцагчдад ил тод мэдээлдэг байна. Докторант нь манлайлах, багшлах, олон улсын багт ажиллахад шаардагдах ур чадвараа хөгжүүлэх боломжийг хичээлийн хөтөлбөрүүдэд тодорхой тусгасан байна.

**Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-ийн Ректорын 2020 оны А/214 тоот тушаалаар баталсан “Докторын сургалтын журам”
- СЭЗИС-ийн Ректорын 2018 оны А/051 тоот тушаалаар баталсан “Багш, оюутны суралцахуйн үр дүнг үнэлэх журам”
- Бизнесийн удирдлагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд зориулсан өөрийн үнэлгээний тайлан
- Бизнесийн удирдлагын докторын сургалтын төлөвлөгөө

**Онцлог зүйл:**

- Сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, хичээл тус бүрийн суралцахуйн үр дүнг тодорхойлсны үндсэн дээр хичээлийн тус бүрийн хувьд хичээлийн хөтөлбөр, тухайн хичээлийн хувьд танхимын ба танхимын бус хэлбэрээр хичээллэх сэдэвчилсэн төлөвлөгөө, шалгалтын хуваарь, үнэлэх журам, ашиглах материал зэргийг багтаасан багц материалыг бэлтгэн ашигладаг.
- Сургалтын багц материалыг боловсруулах стандарт, нэгдсэн форматтай.
- Сургалтын хөтөлбөр боловсруулах ажлыг тэнхим, багш нарын явцуу хүрээнээс гаргаж, сургуулийн хэмжээнд хэлэлцэж баталдаг Хөтөлбөрийн хороог байгуулсан.

**Анхаарах асуудал:**

- Хичээлийн хөтөлбөрүүдээс үзэхэд хичээллэх арга хэлбэрийг гол төлөв танхимд, багш хичээл заах хэлбэрээр гол төлөв явуулахаар төлөвлөсөн байгаад анхаарч, оюутан төвтэй, сургалтын идэвхтэй хэлбэрийг сонгон авах тал дээр анхаарах шаардлагатай.
- Хичээлийн хөтөлбөрт тухайн мэргэжлийн чиглэлээр сүүлийн үед бичигдсэн судалгаа, өгүүллийг ашиглах тал дээр анхаарч, судалгааны өгүүлүүдийг үнэ төлбөргүйгээр татаж авах, ашиглах нөхцлийг бүрдүүлэх тал дээр анхаарах

**Дүгнэлт:**

- Докторын хөтөлбөрт зааж буй хичээлүүдийг хууль тогтоомж, дүрэм журам, олон улсын нийтлэг арга аргачлалд тулгуурлан боловсруулсан.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:**

- Нарийн мэргэжлийн чиглэлээр хичээл сонгон судлах боломжийг өргөтгөх буюу эсвэл өөр бусад сургуульд зааж буй хичээлүүдээс сонгон судлах боломжийг сургалтын хөтөлбөртөө тусгах

### **1.5. Хөтөлбөрт тавих тусгай шаардлага**

Хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн, агуулга нь тухайн хөтөлбөрийн хамаарах ерөнхий, төрөлжсөн, нарийвчилсан чиглэлээр Мэргэжлийн зөвлөлөөс тогтоосон тусгай шаардлага (Зальцбургийн зарчим гэх мэт)-ыг хангахыг эрмэлзэнэ.

#### **Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-ийн Ректорын 2020 оны А/214 тоот тушаалаар баталсан “Докторын сургалтын журам”
- Бизнесийн удирдлагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд зориулсан өөрийн үнэлгээний тайлан
- Бизнесийн удирдлагын докторын сургалтын төлөвлөгөө

#### **Онцлог зүйл:**

- Докторантын судалгаа шинжилгээний ажлыг үр дүнд чиглүүлсэн судалгааны ажлын явцыг хэлэлцэх, ахиц дэвшлийг үнэлэх дүрэм журамтай.

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтын хөтөлбөрт судалгаа шинжилгээний үр чадварыг олгоход чиглэсэн хичээлүүдийг оруулсан боловч тодорхой нарийн мэргэжлийн чиглэлээр хичээл сонгон судлах боломж хязгаарлагдмал байна.
- Докторант сэдвээ сонгосны дараа хичээл сонгож судалдаг байх нь чухал. Одоо хичээлүүдтэй сонгож судалчихаад, судалгаагаа эхлүүлж байгаа нь зарчмын хувьд буруу. Докторант өөрийн хийж буй судалгаанд нь хэрэгцээтэй байгаа мэдлэг, үр чадварыг хичээлээр олж авах ёстой.

#### **Дүгнэлт:**

- Хөтөлбөрийг боловсруулахдаа ерөнхийдөө Зальцбургийн зарчимд нийцүүлэн боловсруулсан.
- Хөтөлбөрт нарийн мэргэжлийн хичээл сонгон судлах боломж хязгаарлагдмал байгаагийн зэрэгцээ судалгааны ажлыг санхүүжүүлэхэд арцуулж буй мөнгөний хэмжээ бага, судалгааны санхүүжилти эх үүсвэрийн хувьд хязгаарлагдмал байна.
- Бусад сургуулиас хичээл сонгон судлах боломжийг хөтөлбөртөө тусгаагүй, бусад сургуультай хамтран хэрэгжүүлж буй судалгааны төсөл байхгүй.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийг боловсруулахдаа ерөнхийдөө Зальцбургийн зарчимд нийцүүлэн боловсруулсан боловч дор дурдсан чиглэлээр хөтөлбөрийг сайжруулах боломж байна. Үүнд:
  - Тодорхой нарийн мэргэжлийн чиглэлээр хичээл сонгон судлах боломж хязгаарлагдмал байгаа тул сонголтын боломжийг өргөжүүлэх.
  - Судалгааны ажлыг санхүүжүүлэх тал дээр анхаарч, судалгааг санхүүжүүлэх олон хэлбэрийг бий болгох,
  - Бусад сургуулиас хичээл сонгон суралцах, бусад сургуультай хамтарсан судалгааг үүсгэх тал дээр анхаарах

## **1-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 2. ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ**

Докторын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчинг бүрдүүлж, докторантын суралцахуй ба судалгааны ажлыг дэмждэг байна.

#### **2.1 Элсэлт**

Элсэгчид тавих шаардлага нь докторын хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх боломжийг тооцсон, шударга, ил тод байна. Элсэгчийн мэргэжлийн болон судалгааны туршлага, ур чадвар, амжилтыг харгалзан тодорхой нөхцөлөөр элсүүлэх боломжийг бүрдүүлэхээс гадна гадаад хэлний (TOEFL, IELTSг.м) болон судалгааны чадавхыг үнэлэх олон улсын үнэлгээг тооцдог байна. Судалгааны сэдэв болон удирдагч багшийг сонгох, санхүүжилтын хэлбэр, хэмжээг тогтоох журмууд нь тодорхой, ил тод байна.

#### **Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-ийн Ахисан түвшний сургалтын нэгдсэн бодлогын баримт бичиг
- СЭЗИС-ийн докторын сургалтын журам
- Ахисан түвшний сургалт, судалгааны бодлогын багийн журам
- Докторын хөтөлбөрт элсүүлэх процессын зураглал
- Сургуулийн цахим хуудас [www.ufe.edu.mn](http://www.ufe.edu.mn)

#### **Онцлог зүйл:**

- Ахисан түвшний сургалтын нэгдсэн бодлогын баримт бичигт Элсэлтийн бодлогоо тодорхойлсон.
- Докторын хөтөлбөрийн элсэгчдэд тавигдах процессийн зураглалтай.
- Элсэгчдэд хөтөлбөрийн талаарх мэдээллийг сонирхолтой хэлбэрээр сургуулийн цахим хуудас болон видео мэдээллээр хангаж, чатботыг ашиглаж буй онцлогтой.

#### **Анхаарах асуудал:**

- Шилдэг сайн элсэгчийг элсүүлэн авч байгааг хэрхэн хэмжиж байгаа

#### **Дүгнэлт:**

- Элсэлтийн бодлогоо тодорхойлж, процессын тодорхой зураглалын дагуу элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулдаг.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:**

- Шинэ, сайн элсэгчдийг татахад бодлогоор дэмжих

## **2.2 Суралцахуйн ачаалал, багц цаг**

Докторантын сургалт, судалгаа, соён гэгээрүүлэх ажлын ачаалал нь улирал бүрд жигд, зохистой хэрэгжиж, хэт ихсэх болон багасахаас сэргийлж, докторантын суралцах хугацаа хэвийн хэмжээнээс хэтрэхгүй байхад чиглэсэн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхээр төлөвлөж, эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

**Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-ийн Ахисан түвшний сургалтын нэгдсэн бодлогын баримт бичиг
- СЭЗИС-ийн докторын сургалтын журам
- Ахисан түвшний сургалт, судалгааны бодлогын багийн журам
- Докторын сургалт, судалгааны агуулга, арга зүй, үнэлгээний стандарт
- Докторын судалгааны ажлын хэлэлцүүлгийн үе шатны зураглал
- Сургуулийн цахим хуудас [www.ufe.edu.mn](http://www.ufe.edu.mn)

**Онцлог зүйл:**

- Докторын сургалт, судалгааны агуулга, арга зүй, үнэлгээний стандарттай.
- Сургалтын төлөвлөгөөг модуль системээр зохион байгуулж буй нь ачааллыг тэнцвэржүүлэхэд ач холбогдолтой.
- Судалгааны ажлын хэлэлцүүлгийн үе шатуудыг урьдчилан төлөвлөдөг.

**Анхаарах асуудал:**

- Докторантын сургалт, судалгааны ачааллыг тэнцвэржүүлэх тал дээр анхаарах

**Дүгнэлт:**

- Суралцахуйн ачааллыг зохистой байдлаар төлөвлөн хэрэгжүүлдэг.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

## **2.3 Багшлахуй ба суралцахуйн арга зүй**

Багшлахуй ба суралцахуйн арга зүй нь суралцагч төвтэй арга барилд тулгуурласан, докторантыг суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад нь дэмжих ба судлаачийн болон мэргэжлийн ёс зүй, арга барилыг дээдлэн хөгжүүлэхэд чиглэсэн байна.

**Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-ийн Ахисан түвшний сургалтын нэгдсэн бодлогын баримт бичиг

- СЭЗИС-ийн докторын сургалтын журам
- Ахисан түвшний сургалт, судалгааны бодлогын багийн журам
- Докторын сургалт, судалгааны агуулга, арга зүй, үнэлгээний стандарт
- Докторын судалгааны ажлын хэлэлцүүлгийн үе шатны зураглал
- Сургуулийн цахим хуудас [www.ufe.edu.mn](http://www.ufe.edu.mn)

#### **Онцлог зүйл:**

- Докторын сургалт, судалгааны агуулга, арга зүй, үнэлгээний стандартад сургах, суралцахуйн 5 зарчмыг дэвшүүлэн мөрдлөг болгон ажиллаж байна.
- Докторантууд руу чиглэсэн судалгааны ажлыг дэмжих семинар зохион байгуулж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Докторантын гүйцэтгэж буй судалгааны ажил болон судалж буй хичээлүүдийн уялдаа холбоог анхаарах

#### **Дүгнэлт:**

- Сургах, суралцахуйд баримтлах зарчим, хэрэглэх аргуудаа тодорхойлсон.

#### **Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Зөвлөмж:**

- Докторантууд руу чиглэсэн сургалтын арга зүйгээ илүү орчин үеийн чиг хандлагатай болгох

### **2.4 Судалгааны ажил**

Докторант, удирдагчийн үйл ажиллагааг харилцан уялдаатай тодорхойлсон ил тод журмаар сургалтын болон ганцаарчилсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу докторантын судалгааны ажлын гүйцэтгэлийг хянан идэвхжүүлэх үйл явцыг тодорхойлсон байна. Удирдагч багш нар нь судалгааны ажлыг удирдах ур чадвартай байна.

#### **Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-ийн Ахисан түвшний сургалтын нэгдсэн бодлогын баримт бичиг
- СЭЗИС-ийн докторын сургалтын журам
- Ахисан түвшний сургалт, судалгааны бодлогын багийн журам
- Докторын сургалт, судалгааны агуулга, арга зүй, үнэлгээний стандарт
- Докторын судалгааны ажлын хэлэлцүүлгийн үе шатны зураглал
- Сургуулийн цахим хуудас [www.ufe.edu.mn](http://www.ufe.edu.mn)

#### **Онцлог зүйл:**

- Докторын сургалтын журамд докторант болон удирдагчийн үйл ажиллагааг сайжруулах зорилго бүхий заалт тусгагдсан.
- Их, дээд сургуулиудын ЭШ, инновацын чадавхыг нэмэгдүүлэх ARROW төсөлд 2018-2020 онд хамрагдсан.

- Бизнесийн удирдлага, Менежментийн чиглэлийн эрдэмтдийн талаарх мэдээллийн бааз үүсгэсэн.

#### **Анхаарах асуудал:**

- Докторантын судалгааны ажлын гүйцэтгэл удирдагч багшийн ажил үүргийн хуваарь, гүйцэтгэлтэй уялдсан байх

#### **Дүгнэлт:**

- Судалгааны ажлыг нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий сэдвийг сонгон шинжлэх ухааны үндэслэлтэй, шинэ онол, арга зүйд суурилан практик ач холбогдолтой, оновчтой шийд гаргахыг зорьдог.

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Зөвлөмж:**

- Докторантын гүйцэтгэж буй судалгааны ажил болон судалж буй хичээлүүдийн уялдаа холбоог анхаарах

#### **2.5 Бүтээлч ажил**

Докторант нь шинжлэх ухааны арга хэмжээ, бага хурал, мэргэжлийн хэлэлцүүлэг зэрэг шинжлэх ухааны болон мэргэжлийн арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцож, судалгааны бүтээлээ хэвлүүлэх боломжийг бүрдүүлсэн байна. Докторантын бүтээлч ажлыг дэмжин урамшуулах, үнэлэх, баталгаажуулах тогтолцоотой байна.

#### **Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-ийн Ахисан түвшний сургалтын нэгдсэн бодлогын баримт бичиг
- СЭЗИС-ийн докторын сургалтын журам
- Ахисан түвшний сургалт, судалгааны бодлогын багийн журам
- Докторын сургалт, судалгааны агуулга, арга зүй, үнэлгээний стандарт
- Докторын судалгааны ажлын хэлэлцүүлгийн үе шатны зураглал
- Сургуулийн цахим хуудас [www.ufe.edu.mn](http://www.ufe.edu.mn)

#### **Онцлог зүйл:**

- Жил бүр ЭШ-ний томоохон хурлыг зохион байгуулж, докторантууд идэвхтэй оролцож байна.
- Шинжлэх ухааны ажилтны өдөр зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг.

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

### **2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### Шалгуур 3. ДОКТОРАНТЫН СУРАЛЦАХУЙН ҮНЭЛГЭЭ, ХӨГЖИЛ

Хөтөлбөрөөр суралцагч нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай хүрэхэд чиглэсэн ил тод, шударга үнэлгээний систем, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх нөөцийг бүрдүүлсэн байна.

#### 3.1 Суралцахуйн үнэлгээ, шалгалт

Хөтөлбөрийн явцад үнэлгээний олон төрөл хэлбэрийг ашиглан суралцагчийн суралцахуйн зорилтот үр дүн (мэдлэг, чадвар, дадал)-ийн гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоог бүрдүүлсэн байна. Үнэлгээний журам, шалгуур нь сургалт, судалгаа, соён гэгээрүүлэх ажлыг бүхэлд нь хамарсан байх ба суралцагчийн амжилтыг шударга ил тод үнэлж, сайжруулахад чиглэсэн байна.

СЭЗИС<sup>1</sup>-ийн хэрэгжүүлж буй докторын хөтөлбөрийн суралцахуйн үнэлгээ, шалгалтыг “Докторын сургалтын журам”<sup>2</sup>, “СЭЗИС-ийн Докторын сургалт, судалгааны агуулга, арга зүй, үнэлгээний стандарт”<sup>3</sup>-аар зохицуулдаг. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлж буй Ахисан түвшний сургуулийн профессор багш нар хичээл тус бүрийнхээ үнэлгээг Infosys удирдлагын мэдээллийн системд ил тод байдлаар бүртгэн, байршуулдаг байна.

Цахим сургалтын талбар (Moodle, Google classroom)-т байршуулсан хичээлийн хөтөлбөр тус бүрт хэрхэн үнэлэх тухай тодорхой зааж, олгох мэдлэг, чадвар, хандлага төлөвшил (CLO), хөтөлбөрийн гарц үр дүн (PLO-1 Асуудал тодорхойлох, PLO-2 Судалгааны дизайн боловсруулах, PLO-3 Задлан шинжлэх, PLO-4 Үнэлэн дүгнэх, PLO-5 Гарц шийдэл олгох, PLO-6 Ёс зүйг баримтлах, PLO-7 Илэрхийлэх чадвар)-тэй уялдуулан хичээл бүрийн суралцахуйн үр дүнгийн тайлан болон тухайн докторантын судалгааны ажлын

#### Илрэл нотолгоо:

- “Докторын сургалтын журам”-ын 6, 10 дугаар бүлэг.
- СЭЗИС-ийн Докторын сургалт, судалгааны агуулга, арга зүй, үнэлгээний стандарт
- Өөрийн үнэлгээний тайлангийн 30-34, 58 дахь тал.
- Цахим сургалтын талбар (Moodle, Google classroom)-т байршуулсан хичээлийн хөтөлбөр, үнэлгээ, шалгалтын хэлбэр, агуулга

#### Дүгнэлт:

- Хөтөлбөрийн үнэлгээг багш бүр стандартад заасан шалгуурыг хангах үнэлгээний рубрикийн аргыг ашиглан суралцахуйн зорилтот үр дүн, гүйцэтгэлийг ил тод үнэлэх тогтолцоог төлөвшүүлж, хичээлийн жил бүрийн төгсгөлд гарц үр дүнгээ хэлэлцэн, сайжруулах арга зам, хийх ажлаа тасралтгүй тодорхойлж хэвшсэн.

<sup>1</sup> Санхүү эдийн засгийн их сургуулийг (цаашид СЭЗИС) гэж товчилсон.

<sup>2</sup> СЭЗИС-ийн Ректорын 2020 оны А/214 тоот тушаалаар баталсан “Докторын сургалтын журам”.

<sup>3</sup> СЭЗИС-ийн Ректорын 2022 оны А/06 тоот тушаалаар баталсан “СЭЗИС-ийн Докторын сургалт, судалгааны агуулга, арга зүй, үнэлгээний стандарт”.



- Үнэлгээнд тавих шалгуур, шаардлагыг журамласан байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

### **3.2. Суралцагчийн хөгжил, суралцахуйн хүрсэн үр дүнг хүлээн зөвшөөрөх**

Хөтөлбөрөөс гадуур суралцагчийн бие даан эзэмшсэн болон өөр сургууль, хөтөлбөрөөс суралцсан суралцахуйн үр дүнг хүлээн зөвшөөрч, багц цагийг дүйцүүлэн тооцох журамтай байна. Түүнчлэн суралцагчийн mobility-г дэмжсэн /багц цагийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, багц цагаас чөлөөлөх/ дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлэхийг эрмэлзэнэ.

Суралцагч нь ижил түвшний сургууль, хөтөлбөрөөс шилжин суралцах боломжтой бөгөөд судалсан хичээлийн үнэлгээг дүйцүүлэн тооцох багц цагийн хэмжээг 20 багц цагаас ихгүй байхаар журамлажээ. Дүйцүүлэн тооцож болох багц цагийг СЭЗИС-ийн Ректорын тушаалаар байгуулсан комисс үнэлж, Ахисан түвшний сургуулийн проректор баталгаажуулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- “Докторын сургалтын журам”-ын 10 дугаар бүлэг. 10.4-10.7 дахь заалт, 17 дугаар бүлэг. 17.2-17.3 дахь заалт, 21 дүгээр бүлэг.
- Өөрийн үнэлгээний тайлангийн 58-59 дэх тал.

#### **Онцлог зүйл:**

- СЭЗИС нь Ази-Номхон далайн их, дээд сургууль(UMAP)-ийн мобилити холбоо зэрэг дотоодын болон гадаадын байгууллагатай гишүүнчлэлийн болон хамтран ажиллах гэрээ, санамж бичгийн хүрээнд сургалт, судалгааны хамтын ажиллагаагаа өргөжүүлэн суралцагчийн хөгжлийг дэмжин ажилладаг байна.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрт мэргэшүүлэх болон сонгон судлах хичээлийг сургуульдаа хэрэгжиж буй ахисан түвшний хөтөлбөрийн хичээлээс, мөн судалгааны ажлын сэдэвтэй холбогдуулан нарийн мэргэжлийн мэдлэг бүтээх бусад сургуулийн ахисан түвшний хөтөлбөрөөс сонгон судлуулах сайн туршлагыг нэвтрүүлэх.

#### **Дүгнэлт:**

- Суралцагчийн ижил түвшний хөтөлбөрөөс шилжин суралцахад хичээлийн болон бүтээлийн суралцахуйн үр дүнг хүлээн зөвшөөрч, багц цагийг дүйцүүлэн тооцож, суралцагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр тухайн харилцааг журамласан байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Зөвлөмж:**

- Докторантууд нь одоогоор зөвхөн докторын хөтөлбөрт нэр заасан хичээлийг судлаж байгаа бөгөөд цаашид ахисан түвшний хөтөлбөр (СЭЗИС-ийн магистрын хөтөлбөр, бусад ижил түвшний хөтөлбөр хэрэгжүүлж буй их

сургуулиудын хөтөлбөрөөс судалгааны сэдэв чиглэлд дэмжлэг үзүүлэхүйц хичээл)-өөс сонгон суралцах боломжийг тодорхой болгох

### **3.3. Суралцагчийг дэмжих, зөвлөх үйлчилгээ**

Суралцагчдыг амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь дэмжих, зөвлөх үйлчилгээг системтэйгээр үзүүлэх нөөцийг бүрдүүлсэн байна. Дэмжих, зөвлөх үйлчилгээ нь суралцагч /гадаад, шилжин ирсэн, ажил эрхэлдэг ба эрхэлдэггүй, боловсролын тусгай хэрэгцээт гэх мэт/-ийн хэрэгцээ, шаардлагаас үүдэх сургалтын орчин, нийгэм, сэтгэл зүйн асуудлыг шийдэхэд тусалж, сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн байна. Докторантын санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл явцыг тэдэнд нээлттэй мэдээлж, албан ёсны гомдлыг бүртгэж баримтжуулан, шийдвэрлэдэг байна.

Суралцагчийн амжилттай суралцахад чиглэсэн (сургуулийнхаа тухайн хөтөлбөрт суралцаж буй докторант багш нарт сургалтын төлбөрийн 30 хувийн хөнгөлөлт) санхүүгийн дэмжлэг, хөгжиж төлөвшихөд нь чиглэсэн зөвлөн туслах үйлчилгээ (Гадаад улсаас тухайн хөтөлбөрт суралцагч: гадаад суралцагч хариуцсан мэргэжилтэн тогтмол мэдээлэл өгч, чиглүүлэгчээр ажилладаг, суралцахын зэрэгцээ хөдөлмөр эрхэлдэггүй тул сургалт, судалгааны ажилдаа илүү сайн төвлөрдөг)-г үзүүлдэг. Суралцагчдын багаар ажиллах, судалгааны ажилдаа төвлөрөх, тухайн салбарын мэргэжилтнээс зөвлөгөө авах гэх мэт хэрэгцээ, шаардлагад үндэслэн Intensive seminar, Retreat camp, Academic collaboration зэрэг семинар, хэлэлцүүлгийг зохион байгуулдаг. Тухайлбал, 2021-2022 оны хичээлийн жил буюу 2022 оны 6 дугаар сарын 20-25-ны хооронд 1, 2 дугаар түвшний нийт 10 докторантыг хамруулан агуулгын хувьд онолын судалгаанд төвлөрсөн байдлаар “Retreat camp”-ыг зохион байгуулж докторантуудад диссертац бичихэд нь зөвлөгөө, туслалцаа үзүүлжээ.

Суралцагчийн санал, хүсэлт, гомдлыг биечлэн болон цахим(Infosys систем)-аар хүлээн авч, тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй холбогдох ажилтан, албан тушаалтан өөрсдийн эрхлэх асуудлын хүрээнд удирдлага мэдээллийн систем (APPZ)-ээр хариу өгдөг ч бүртгэлжүүлэн ажилдаг.

#### **Илрэл нотолгоо:**

- “Докторын сургалтын журам”-ын 2, 7 дугаар бүлэг.
- Өөрийн үнэлгээний тайлангийн 60-63, 122-123 дахь тал.
- Writing Retreat Camp зохион байгуулсан тайлан, 2022 оны 6 сар.
- Шинжээчдийн багийн тухайн хөтөлбөрийн суралцагч, төгсөгчдийн төлөөлөлтэй хийсэн уулзалтын тэмдэглэл.

#### **Дүгнэлт:**

- Суралцагчийг дэмжин туслах үйлчилгээг хөтөлбөрийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажилладаг байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

### **3.4. Судалгааны санхүүжилт**

Сургуулийн судалгааны бодлого, хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн, докторантын судалгааны ажлыг олон эх үүсвэрээс санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах,

гүйцэтгэлийг үнэлэх ил тод бодлого, журамтай байна.

Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд сургуулийн судалгааны бодлого, хөтөлбөрийг шинэчлэн батлах, хэрэгжилтийг хангах механизмыг бэхжүүлэхэд чиглэсэн ажил үйлчилгээг эрхэлж ирсэн байна. Санхүү эдийн засгийн их сургуулийн судалгааны тэргүүлэх 7 чиглэл<sup>4</sup>, Стратеги төлөвлөгөө (2021-2031)<sup>5</sup> зэрэг бодлогын баримт бичгийг сургуулийн эрхэм зорилго, алсын хараад нийцүүлэн баталж, судалгааны санхүүжилтийг олон эх үүсвэрээс татах, гүйцэтгэлийг хянах механизмыг бэхжүүлэн ажилладаг.

#### **Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-ийн судалгааны төсөлт ажлыг зохицуулах журам"-ын 4.1.1.
- Өөрийн үнэлгээний тайлангийн 63-64 дэх тал.
- Шинжээчдийн багийн тухайн хөтөлбөрийн суралцагч, багш нарын төлөөлөлтэй хийсэн уулзалтын тэмдэглэл.

#### **Онцлог зүйл:**

- СЭЗИС нь 2012-2020 оны хооронд олон улсын санхүүжилт бүхий 4 төсөл хөтөлбөрт багш, суралцагчдаа оролцуулсан байна.

#### **Дүгнэлт:**

- Сургуулийн судалгааны тэргүүлэх 7 чиглэлийг баталж, багш, судлаач, суралцагчдын төсөлт ажлыг дэмжих, санхүүжилтийн олон эх үүсвэрийг бий болгоход чиглэсэн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулан ажиллаж иржээ.

#### **Үнэлгээ:** Бүрэн хангасан

### **3.5. Тэтгэлэг, тэтгэмж**

Докторантын сургалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, тэтгэлэг, тэтгэмж олгох нөхцөл, болзлыг тодорхой заасан дүрэм журамтай байхын зэрэгцээ түр болон байнгын ажлын байраар хангах боломжийг судалсан байна.

Сургуулийнхаа тухайн хөтөлбөрт суралцаж, хугацаандаа хамгаалсан доктор багш нарт сургалтын төлбөрийн 100 хувь тэтгэлэг хэлбэрээр буцаан олгодог. Мөн докторантурт суралцаж буй багш нартаа 6 сарын цалинтай бүтээлийн чөлөө олгон амжилттай хамгаалахад нь дэмжлэг үзүүлэн тэтгэмж олгосон. Мөн Erasmus хөтөлбөрт 5 докторантыг хамруулсан байна.

Докторын хөтөлбөр нь ажил эрхлэлтийн хувьд онцлогтой бөгөөд суралцагч, төгсөгчдийн олонх нь их, дээд сургуульд багшлах болон салбарын удирдах ажилтнаар ажилдаг байна. Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойш нийт 17 доктор хамгаалсан бөгөөд эдгээр төгсөгчдийн 8 нь сургуульдаа ажилладаг байна. Түүнчлэн төрийн болон хувийн хэвшилд ажиллаж буй төгсөгчдийн хувьд судалгааны чиглэлийн дагуу төсөл хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гаргаж буйгаа уулзалтын явцад илэрхийлсэн болно.

#### **Илрэл нотолгоо:**

<sup>4</sup> СЭЗИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2021 оны Дугаар 01 тогтоолоор баталсан “Судалгааны тэргүүлэх чиглэл батлах тухай”.

<sup>5</sup> СЭЗИС-ийн Удирлах зөвлөлийн 2021 оны Дугаар 21/01 тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө, бүтэц батлах тухай”.

- “СЭЗИС-ийн Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”<sup>6</sup>-ийн 6, 7, 8.
- Өөрийн үнэлгээний тайлангийн 57, 65 дахь тал.
- Шинжээчдийн багийн тухайн хөтөлбөрийн төгсөгч, ажил олгогчдын төлөөлөлтэй хийсэн уулзалтын тэмдэглэл.

#### **Анхаарах асуудал:**

- Зөвхөн дотоодын буюу их сургуулийнхаа багш, ажилтанд тэтгэлэг, тэтгэмжийг олгож буй нь санхүүгийн хязгаарлагдмал боломжоос үүдэлтэйг харгалзан үзэж байгаа ч, бусад байгууллагаас болон хувиараа боловсролын зэргээ ахиулан суралцаж буй суралцагчдыг дэмжих, суралцах хугацаанд нь төслийн багт цалинжуулан ажиллах зэргээр хүрээг нь тэлэх

#### **Дүгнэлт:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүүжилтийн олон эх үүсвэр болон сургуулийн дотоодын тэтгэлэг, тэтгэмж олгох нөхцөл, болзолыг заасан журамтай. Тухайн сургуульд ажиллаж буй докторант багш нарийн хувьд байнгын ажлын байртай, ажлын ачаалал өндөртэй байдаг талаараа уулзалтын явцад дурдсан болно.

#### **Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Зөвлөмж:**

- Докторын хөтөлбөр өөрөө онцлог бөгөөд хэрэгжүүлэгч их сургуулийн эрдмийн нэр хүндийг өргөжүүлэх, тухайн улсын төдийгүй бүс нутаг, олон улсад эрэмбэ тогтооход бодитой хувь нэмэр оруулдаг хөтөлбөр юм. Иймд гадаадын болон дотоодын байгууллагын тэтгэлэг, дэмжлэгээр суралцах докторантын тоог нэмэгдүүлэхэд анхаарал хандуулах, судалгааны бүтээлийг нь эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах боломжийг цаашид эрэлхийлэх

### **3.6. Судалгааны баг, хамтын ажиллагаа**

Хөтөлбөрийн түвшинд үндэсний болон олон улсын, төрийн болон хувийн байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааг байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагуудтай хамтын дотоодын болон гаднын судалгааны нэгж, байгууллагуудтай холбоо тогтоож, түншлэх, багш, докторантууд судалгааны багт оролцох боломж нөхцөлийг тандан судалж, зарим ажлыг эхлүүлсэн байна.

Тус их сургууль нь хамтын ажиллагааны хүрээнд дотоодын боловсролын болон бусад салбарын төрийн болон хувийн хэвшлийн 100 гаруй, гадаадын их, дээд сургууль, нийгэмлэг, мэргэжлийн 60 гаруй байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, үндэсний болон олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэн түгээн дэлгэрүүлэх зорилготой ажилладаг байна.

<sup>6</sup> СЭЗИС-ийн Ректорын 2019 оны А/069 тоот тушаалаар баталсан “СЭЗИС-ийн Хүний нөөцийн бодлогын баримт бичиг батлах тухай”

<sup>7</sup> <https://www.ufe.edu.mn/c/63>

Профессороор ахлуулсан судалгааны 25 багт<sup>8</sup> сэдвийн хүрээнд хуваагдан зарим судалгааны ажлыг эрхэлж буй талаараа танилцуулсан болно.

#### **Илрэл нотолгоо:**

- “Багш, судлаач, зөвлөхүүдийн багийн ажиллах журам”<sup>9</sup>
- Өөрийн үнэлгээний тайлангийн 65 дахь тал.
- Шинжээчдийн багийн тухайн хөтөлбөрийн суралцагч, багш нарын төлөөлөлтэй хийсэн уулзалтын тэмдэглэл.

#### **Онцлог зүйл:**

- Хөтөлбөрийн зорилгодоо нийцүүлэн суралцагчдыг судалгааны сэдвээр нь ангилан багт хуваарилж, зөвхөн удирдагч багш, зөвлөхөөс гадна тухайн сэдвийн хүрээнд нэгдсэн багаар зөвлөн туслах үйлчилгээг туршиж байгаа талаар уулзалтын хүрээнд дурдсныг сургуулийн материаллаг орчинтой танилцах явцдаа зарим багийн хэрэгжүүлж буй төсөлтэй танилцсан болно.

#### **Дүгнэлт:**

- Хөтөлбөрийн түвшинд дотоод, гадаадын хамтын ажиллагааг өргөжүүлсэн, профессор багшаар удирдуулсан судалгааны багт докторантыг өөрийн судалгааны сэдвийн дагуу орж судалгааны туршлага хуримтлуулах болон өөрийн судалгааг багаар гүйцэтгэх, дэмжлэг авах нөхцөлийг бүрдүүлжээ.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

### **3.7. Диссертац хамгаалах**

Диссертац хамгаалах зөвшөөрөл олгох (шинэ мэдлэгийг бий болгох, үр дүнг ашиглах, багшлахуйн үнэлгээ, шилжилт хөдөлгөөн гэх мэт) тодорхой шалгууруудыг боловсруулсан байна. Диссертац хамгаалалтыг зохион байгуулах дүрэм (хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүдийн чиг үүрэг, хурлын дэг, танилцуулга хийх г.м.)-ийг докторант, удирдагч нарт тодорхой, шударга, ил тод байдлаар тодорхойлсон байна

Докторын диссертац нь шинжлэх ухааны шинэ мэдлэг бий болгоход тодорхой хувь нэмэр оруулсан эрдэм шинжилгээ, судалгааны бие даасан бүтээл болохын хувьд нийтлэг болон их сургуулийн Докторын сургалтын журамд заасан нарийвчилсан шаардлагыг хангасан байна. Диссертацын хамгаалалтыг зохион байгуулах процессын үе шат бүрийг тодорхой зааж, нарийвчилсан удирдамж боловсруулан хэрэгжүүлдэг давуу талтай.

#### **Илрэл нотолгоо:**

- “Докторын сургалтын журам”-ын 12-16 дугаар бүлэг.
- Докторын диссертац бичих явц, явцын хэлэлцүүлгийн удирдамж<sup>10</sup>

<sup>8</sup> <https://www.ufe.edu.mn/c/92>

<sup>9</sup> СЭЗДС-ийн Захирлын 2014 оны 298 тоот тушаалаар баталсан “Багш, судлаач, зөвлөхүүдийн багийн ажиллах журам”.

<sup>10</sup> СЭЗИС-ийн Ректорын 2017 оны баталсан “Докторын диссертац бичих явц, явцын хэлэлцүүлгийн удирдамж”.

- Докторын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний төгсөлтийн ажил хэсэгт багц цаг тооцуулах (Судалгааны семинар I,II, Их семинар, Урьдчилсан хамгаалалт)
- Өөрийн үнэлгээний тайлангийн 65-67 дахь тал.
- Шинжээчдийн багийн тухайн хөтөлбөрийн суралцагч, төгсөгч, багш нарын төлөөлөлтэй хийсэн уулзалтын тэмдэглэл.

#### **Онцлог зүйл:**

- Диссертацыг Судалгааны семинар I,II, Эрдмийн зөвлөлөөр сэдэв батлуулах, Тэнхимийн өргөтгөсөн зөвлөлийн хэлэлцүүлэг (Их семинар), Урьдчилсан хамгаалалт, Жинхэнэ хамгаалалт гэсэн 6 үе шаттайгаар хэлэлцүүлэн хамгаалдаг бөгөөд эхний 4 үе шатыг СЭЗИС хэрэгжүүлдэг байна.

#### **Дүгнэлт:**

- Диссертацын хамгаалалтыг СЭЗИС-ийн Докторын сургалтын журам, Докторын диссертац бичих явц, явцын хэлэлцүүлгийн удирдамж, БШУ-ны сайдын 2021 оны А/92 тоот тушаалаар баталсан “Докторын зэрэг хамгаалах зөвлөлийн дүрэм”-ийг дагаж мөрддөг.

#### **Үнэлгээ:** Бүрэн хангасан

### **3.8. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөгчид, суралцсан хөтөлбөрийн хичээл тус бүрээр мэдлэг, ур чадвар, дадлын түвшинг жагсаасан хавсралт (англи хэл) бүхий диплом, баримт бичиг олгох үйл явцыг холбогдох журмын хүрээнд хэрэгжүүлдэг байна. Төгсөгчид олгох баримт бичгүүд нь тухайн оюутны чадамжийн тухай мэдээлэл болон хөтөлбөрийн тодорхойлолт, суралцахуйн үр дүн, агуулга, түвшин түүнчлэн боловсрол, мэргэшлийн зэрэгтэй холбоотой мэдээллүүдийг багтаасан байна.

Докторын хөтөлбөрийн төгсөгчид олгох төгсөлтийн баримт бичгийн загварыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Боловсролын баримт бичгийн загвар”<sup>11</sup>-т нийцүүлэн баталж, төгсөгчийн судалсан хичээлийн үнэлгээг хавсралтад тусган олгож хэвшсэн. Төгсөгчдийн диплом баримт бичгийн эх хувийг 2019 оноос эхлэн Блокчэйн технологийг ашиглан баталгаажуулж байгаа нь цахим суурьтай баримт бичгийн санг бүрдүүлж буй сайн талтай бөгөөд төгсөгчдөд лавлагаа авах, гээгдүүлсэн тохиолдолд дахин авахад цаг хугацааны хувьд чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлдэг болсон байна.

#### **Илрэл нотолгоо:**

- “Докторын сургалтын журам”-ын 16 дугаар бүлэг. 16.3 дахь заалт
- Өөрийн үнэлгээний тайлангийн 67-70 дахь тал.
- Диплом дахин олгох процессын зураглал.
- Төгсөгчид 2023 онд олгосон Докторын диплом, хавсралт (хуулбар).

#### **Анхаарах асуудал:**

<sup>11</sup> БСШУ-ны сайдын 2012 оны дугаар 01 тушаалаар баталсан “Боловсролын баримт бичгийн загвар шинэчлэн батлах тухай”.

- Докторын дипломын хавсралтад хэвлэгдэж буй хичээлийг зохистой байдлаар эрэмбэлэх

#### **Дүгнэлт:**

- захиргааны төв байгууллагаас баталсан “Боловсролын баримт бичгийн загвар” –т нийцүүлэн баталсан.
- Төгсөлтийн баримт бичиг олгох харилцааг журамласан.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Зөвлөмж:**

- Докторын дипломын хавсралтад хэвлэгдэх хичээлийг докторын сургалтын төлөвлөгөө (Судалгааны арга зүй, мэргэжлийн, мэргэшүүлэх, төгсөлтийн ажил)-ний дагуу эрэмбэлэн баримт бичгийн эмх цэгцтэй байдлыг хангах нь зүйтэй.
- Түүнчлэн сонгон судалсан болон багц цаг тооцохгүй хичээлийн үнэлгээг судалсан (тооцов) гэж тэмдэглэн хавсралтад дурдсан хичээлийн сүүлийн эрэмбэд байршуулах нийтлэг туршлага буйг судлан үзэхийг зөвлөж байна.

**3-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ:** Бүрэн хангасан

### **Шалгуур 4. БАГШЛАХ БҮРЭЛДЭХҮҮН**

Докторын хөтөлбөрийн онцлогоос хамааран шинжлэх ухааны салбар ба суралцагчийн тоонд дүйцэх, хангалттай хүрэлцээтэй багшлах бүрэлдэхүүнтэй байна.

#### **4.1. Багшийн нөөц**

Тухайн хөтөлбөрийн мэргэжлийн чиглэл, боловсролын зэргийн түвшинд тохирсон боловсролын зэрэг, эрдмийн цолтой, багшлах өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багш, судлаачийн нөөцтэй байна. Багш, докторантын тооны харьцааг зохистой тогтоож мөрддөг байна. Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор үндэсний болон олон улсын тэргүүлэх судлаач, эрдэмтдийг хөтөлбөрт урьж ажиллуулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-ийн Ректорын 2018 оны А/051 тоот тушаалаар баталсан “Багш, оюутны суралцахуйн үр дүнг үнэлэх журам”
- Бизнесийн удирдлагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд зориулсан өөрийн үнэлгээний тайлан
- Бизнесийн удирдлагын докторын сургалтын төлөвлөгөө

#### **Онцлог зүйл:**

- Докторын сургалтыг явуулахад хангалттай хэмжээгээр хүрэлцэх багшлах бүрэлдэхүүний нөөцтэй



- Салбартаа танигдсан, мэдлэг, чадвар өндөртэй багш нар ажиллаж буй нь давуу талтай
- Багшлах бүрэлдэхүүн нь гадаад, дотоодын их дээд сургуулиудад төрөл бүрийн чиглэлээр мэдлэг боловсрол эзэмшсэн
- Ахисан түвшний оюутны тоо нийт оюутанд эзлэх хувь өндөр.

#### **Анхаарах асуудал:**

- Эрдмийн зэрэгтэй багш ба ахисан түвшний оюутны тооны харьцаа 1:50 орчим байгаа нь олон улсын дундаж үзүүлэлт болох 1:15 -аас хэт өндөр байна.
- Нийт багш нарын дотор докторын зэрэгтэй багшийн эзлэх хувийн жин бага. Ахисан түвшинд сургалт явуулах багшийн ачаалал хэт их

#### **Дүгнэлт:**

- Ахисан түвшний оюутны эзлэх хувийн жин их, тэдэнд хичээл заах хангалттай хэмжээний нөөцтэй боловч эрдмийн зэрэгтэй нэг багшид ногдох тоо хэт олон, багш нарын ажлын ачаалал хэт их

#### **Үнэлгээ:** Хэсэгчлэн хангасан

#### **Зөвлөмж:**

- Бүх багш нараа докторын зэрэг хамгаалуулах замаар зарим багш нарт, ялангуяа ахисан түвшинд багшилж байгаа багш нарын ажлын ачааллыг бууруулах
- Докторын сургалтад заах хичээл, багш нарын тоог олшруулах

#### **Шаардлага:**

- Ахисан түвшинд ажиллаж буй багшийн хичээлийн цагийн ачаалал хэт өндөр байгааг анхаарч бууруулах, багш нарын судалгаандаа төвлөрч ажиллах боломжийг сайжруулах

#### **4.2. Багшлахуйн үнэлгээ**

Багшлахуйн үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, үнэлгээний үйл явцыг тодорхой журамлан, хөтөлбөрийн зорилго, зорилтуудад нийцүүлэн багшийн ур чадварыг шударга, бодитой, системтэй, тогтмол үнэлж, үнэлгээний үр дүнг цаг тухайд нь танилцуулдаг байна. Чадахуйд суурилсан үнэлгээний тогтолцоо нь багшийн байнгын хөгжлийг дэмждэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-ийн Ректорын 2018 оны А/051 тоот тушаалаар баталсан “Багшийн хөдөлмөр, түүнийг үнэлэх, дүгнэх журам”

#### **Онцлог зүйл:**



- Багшийн сургалт, судалгааны ажлыг үнэлэх, дүгнэх журам, гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд тулгуурлан урамшуулах тогтолцоотой

#### **Анхаарах асуудал:**

- Эрдэм шинжилгээний өндөр түвшний ажлын үнэлгээ бага, зэрэглэлд тавигдах шаардлагад өндөр түвшний бүтээлийг гол шалгуур болгоогүй
- Судалгааны ажлыг нь удирдан чиглүүлж буй багшийн ажлыг удирдаж буй докторантынх судалгааны ажилтай нь холбосон дүрэм журам, зохицуулалт байхгүй

#### **Дүгнэлт:**

- Багшийн сургалт, судалгааны ажлыг үнэлэх, дүгнэх журам, урамшуулах тогтолцоотой боловч өндөр түвшний судалгааг дэмжих бодлого сул.

#### **Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Зөвлөмж:**

- Удирдагч багшийн удирдлага дор докторантын докторантын хийж гүйцэтгэх судалгааг дэмжих, өндөр түвшний судалгааг дэмжихэд чиглэсэн зохицуулалт, санхүүжилтийн олон эх үүсвэрийг бий болгох тал дээр анхаарч ажиллах.

### **4.3. Багшийн хөгжил**

Багш нар мэргэжлийн болон багшлах ур чадвараа дээшлүүлэх, судалгаа шинжилгээ хийх, докторын судалгаа удирдах ур чадвараа ахиулахад нь чиглэсэн үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлж, боловсролын үйлчилгээнд шинэ арга зүй, инновац нэвтрүүлэхийг дэмжин урамшуулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-ийн Ректорын 2018 оны А/051 тоот тушаалаар баталсан “Багшийн хөдөлмөр, түүнийг үнэлэх, дүгнэх журам”
- СЭЗИС-ийн Ректорын 2018 оны А/156 тоот тушаалаар баталсан “СЭЗИС-ийн багшийн албан тушаалын зэрэглэл, түүнд тавигдах шаардлага”

#### **Онцлог зүйл:**

- Багшийн сургалт судалгааны ажлыг дэмжих, урамшуулах тогтолцоотой.
- “СЭЗИС-ийн багшийн албан тушаалын зэрэглэл, түүнд тавигдах шаардлага”-ыг боловсруулан мөрдөж байна.
- Багш бүр өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, жил бүр өөрийн үнэлгээний тайланг бичдэг.
- Багш нар туршлагаа солилцох, шинэ зүйлд суралцах боломжийг moodle талбар, багш ажилтны дотоод E-office-г ашиглан хэрэгжүүлж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Докторын хөтөлбөрт багшилдаг багш нарын судалгаа шинжилгээний ажлын цар хүрээ хэмжээг өргөжүүлэх, энэ тал дээр нь үзүүлэх дэмжлэг туслалцааг сайжруулахад анхаарах нь чухал. Мөн хийж гүйцэтгэсэн судалгаа шинжилгээний ажлуудаа олон улсад хэвлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх нь чухал.

#### **Дүгнэлт:**

- СЭЗИС нь багшийн сургалт судалгааны ажлыг үнэлэх, урамшуулах, зэрэглэлд шалгаруулан ажиллуулах тогтолцоо, багшийг өөрийгөө хөгжүүлэх ажил руу чиглүүлсэн дүрэм журам, зохицуулалттай. Гэхдээ багш нарын хийж гүйцэтгэж буй судалгаа шинжилгээний ажлыг цар хүрээ, хэмжээ, түвшингийн хувьд нэмэгдүүлэх боломж байна.

#### **Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Зөвлөмж:**

- Цаашид багш нарын, ялангуяа докторын судалгааг удирддаг багш нарын гүйцэтгэх судалгаа шинжилгээний ажлын цар хүрээг өргөжүүлэх тал дээр анхаарах шаардлагатай. Энэ нь судалгаа шинжилгээний ажилд докторын оюутнуудаа татан оролцуулах, тэдэнд судалгаа шинжилгээний ажил хийх мэдлэг, чадвар олгоход тустай.

#### **4.4. Судалгаа ба хөгжил**

Багш нар хөтөлбөрийн судлагдахуунтай холбоотой судалгааны ажлыг идэвхтэй хийдэг, шаардлагатай тохиолдолд судалгааны баг бүрдүүлж, докторантуудыг судалгаанд татан оролцуулдаг байна. Үүний зэрэгцээ үндэсний болон олон улсын эрдэмтдийн баг, сүлжээ, мэргэжлийн байгууллагын идэвхтэй гишүүн байхыг сургуулийн зүгээс дэмждэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-ын Ректорын 2018 оны А/054 тоот тушаалаар баталсан “Ахисан түвшний сургалт, судалгааны бодлогын багийн ажиллах журам”
- СЭЗИС-ийн Ректорын 2018 оны А/051 тоот тушаалаар баталсан “Багшийн хөдөлмөр, түүнийг үнэлэх, дүгнэх журам”
- СЭЗИС-ийн Ректорын 2018 оны А/156 тоот тушаалаар баталсан “СЭЗИС-ийн багшийн албан тушаалын зэрэглэл, түүнд тавигдах шаардлага”
- Бизнесийн удирдлагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд зориулсан өөрийн үнэлгээний тайлан

#### **Онцлог зүйл:**

- СЭЗИС нь энтрепренёр их сургууль болох зорилтынхоо хүрээнд дэвшүүлсэн судалгааны тэргүүлэх чиглэлүүдээр ахисан түвшний сургалт, судалгааны бодлогын багуудыг ажиллуулдаг.

- Тодорхой шаардлагыг хангасан судалгааны багуудын үйл ажиллагааг сургуулийн зүгээс санхүүжүүлдэг.

#### **Анхаарах асуудал:**

- Хатуу тогтоосон бүтэцтэй судалгааны баг нь багш нарын академик эрх чөлөөг хязгаарлаж болзошгүй.
- Судалгааны ямар нэгэн багт хамрагдаагүй багш судалгаагаа хэрхэн гүйцэтгэх, судалгааны санхүүжилтийг хэрхэн олж авах вэ гэдэгт анхаарах шаардлагатай.

#### **Дүгнэлт:**

- СЭЗИС нь судалгаа хөгжүүлэлтийн тал дээр ажиллах бүтэц зохион байгуулалтыг бий болгосны зэрэгцээ тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах, санхүүжүүлэх дүрэм журмуудаа боловсруулсан. Гэхдээ багш бүрийг судалгаа шинжилгээний ажилд татан оролцуулах, тэдэнд ижил тэгш боломжийг олгох нь чухал юм.

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Зөвлөмж:**

- Судалгааны багт орж чадаагүй багш нарыг судалгааны ажилд хэрхэн татан оролцуулах, тэдний судалгааг хэрхэн санхүүжүүлэх, багш нарын академик эрх чөлөөг хэрхэн хангах зэрэг асуудалд анхаарах шаардлагатай.

#### **4-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 5. НӨӨЦ БА САНХҮҮЖИЛТ**

Суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх, судалгааны ажлыг чанартай хийхэд шаардагдах нөөцийг бүрдүүлж, нөөцийн хуваарилалт болон гүйцэтгэлийг хянах, хөтөлбөрийн байнгын хөгжлийг дэмжих санхүүгийн хангалттай эх үүсвэртэй байна.

#### **5.1. Сургалт, судалгааны орчин**

Тухайн хөтөлбөр, шинжлэх ухааны чиглэлээр докторант идэвхтэй суралцах, судалгаа хийх анги танхим, лаборатори, зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийг бүрдүүлж, багш суралцагчдын сэтгэл ханамжид үндэслэн сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-ийн сургалтын бааз, материаллаг орчны дүрслэл
- СЭЗИС-ийн ахисан түвшний суралцагчид хичээллэдэг анги, танхимийн судалгаа
- Докторын хөтөлбөрийн лаборатори, анги, танхимуудын судалгаа
- Сургуулийн цахим хуудас [www.ufe.edu.mn](http://www.ufe.edu.mn)

### **Онцлог зүйл:**

- Судалгааны хэлэлцүүлэг хийх, багийн ажил зохион байгуулах зориулалт бүхий лабораториудын багтаамж хүрэлцээтэй.
- Барилга, байгууламжийг сайжруулан шинэчлэхэд зарцуулж буй санхүүгийн зарцуулалт жилээс жилд өсөн нэмэгдэж байна.

### **Дүгнэлт:**

- Дээд боловсролын сургалтын байгууллагад тавигдах сургалт, судалгааны орчны шаардлагыг бүрэн хангаж байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

### **5.2. Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн**

Хичээл тус бүрээр үндсэн сурах бичиг, сургалт, судалгааны хэрэглэгдэхүүнийг хангалттай бүрдүүлж, судалгааны ажилд шаардлагатай мэдээлэл, үр дүнгүүдийг багш, докторантууд хэвлэмэл болон цахим хэлбэрээр нээлттэй ашигладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-ийн сургалтын бааз, материаллаг орчны дүрслэл
- СЭЗИС-ийн ахисан түвшний суралцагчид хичээллэдэг анги, танхимийн судалгаа
- Докторын хөтөлбөрийн лаборатори, анги, танхимуудын судалгаа
- Сургуулийн цахим хуудас [www.ufe.edu.mn](http://www.ufe.edu.mn)

### **Онцлог зүйл:**

- Гэрээр ном олгох фонд, эрдэм шинжилгээ, судалгааны фонд, гадаад ном, бизнес мэдээллийн фонд, тогтмол хэвлэлийн фонд зэргээс уншлагын танхимууд бүрдэж байна.
- 2023 оны байдлаар 65200 гаруй номын фондтой, Бизнесийн удирдлага, Менежмент хөтөлбөрийн хүрээнд жил бүр ном сурах бичгийн тоо өсөн нэмэгдэж байна.

### **Анхаарах асуудал:**

- Нийт сурах бичгийн тоо хэмжээ хэмжээнд эзлэх докторын хөтөлбөрт хамаарах номын фондыг нэмэгдүүлэх

### **Дүгнэлт:**

- Дээд боловсролын сургалтын байгууллагад/ахисан түвшний сургалтад тавигдах номын сангийн шаардлагыг хангаж байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:**

- Нийт сурах бичгийн тоо хэмжээ хэмжээнд эзлэх докторын хөтөлбөрт хамаарах номын фондыг сайжруулах

### 5.3. Төсөв, санхүүжилт

Хөтөлбөр олон эх үүсвэрээс санхүүжих ба хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээ хийх, шинэчлэх төсөвтэй байна. Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувийг багшлахуй, суралцахуйн хөгжилд зарцуулдаг, үүнд багш нарын саналыг харгалздаг байна.

#### Илрэл нотолгоо:

- СЭЗИС-ийн сургалтын бааз, материаллаг орчны дүрслэл
- СЭЗИС-ийн ахисан түвшний суралцагчид хичээллэдэг анги, танхимийн судалгаа
- Докторын хөтөлбөрийн лаборатори, анги, танхимуудын судалгаа
- Сургуулийн цахим хуудас [www.ufe.edu.mn](http://www.ufe.edu.mn)

#### Онцлог зүйл:

- Сургалт, судалгааны орчин, нөөц санхүүжилт, номын сангийн үйл ажиллагааг явуулах, сайжруулахад 18 төрлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

#### Анхаарах асуудал:

- Эдийн засгийн үр ашиг талаасаа докторын хөтөлбөрийг магистрын хөтөлбөртэйгээ интеграцичлах

Үнэлгээ: Бүрэн хангасан

#### Зөвлөмж:

- Хөтөлбөрийн санхүүжилтыг бусад эх үүсвэрээс олох нөхцлийг бүрдүүлэх

**5-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## Шалгуур 6. УДИРДЛАГА БА МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ

Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд нийцсэн засаглал ба удирдлагын тогтолцоотой, захиргааны зохистой бүтэц, удирдлагын мэдээллийн системтэй байна.

### 6.1. Засаглал ба удирдлага

Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд туслах үр ашигтай засаглал, удирдлагын тогтолцоо, захиргааны бүтэцтэй байх ба академик эрх чөлөө, ёс зүйн хариуцлагыг дэмждэг байна.

СЭЗИС нь хэрэгжүүлж буй докторын хөтөлбөрөө мэргэжлийн удирдлагаар хангах чиглэлийн хүрээнд 2009 онд Сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны бүрэлдэхүүнд

Докторын сургалтын алба, 2022 онд Ахисан түвшний сургууль<sup>12</sup> байгуулан өргөжүүлсэн байна. Ахисан түвшний сургууль нь сургалтын алба, Ахисан түвшний профессорын баг, Эрдэм шинжилгээний бүтээлийн номын сан гэсэн зохион байгуулалттайгаар хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

#### **Илрэл нотолгоо:**

- “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.5-4.8,
- “СЭЗИС-ийн Хүний нөөцийн бодлогын баримт бичиг” -ийн 8.
- Өөрийн үнэлгээний тайлангийн 120-123 дахь тал.
- Шинжээчдийн багийн тухайн хөтөлбөрийн суралцагч, багш нарын төлөөлөлтэй хийсэн уулзалтын тэмдэглэл.

#### **Дүгнэлт:**

- Докторын хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэргэжлийн удирдлагын тогтолцоонд шилжин ажиллаж буй нь хөтөлбөрийн шинэтгэл болон оролцогч талуудыг идэвхжүүлэх, үр ашигтай хамтын ажиллагааг төлөвшүүлэхэд нөлөөлжээ.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **6.2. Ажилтнууд**

Захиргааны болон туслах ажилтны орон тоо хангалттай, зохих ур чадвар, туршлагатай байна. Захиргааны болон туслах ажилтныг ажил мэргэжилдээ өсөн дэвжих, мэргэжил дээшлүүлэх, насан туршийн боловсролд нь дэмжлэг үзүүлдэг байна.

СЭЗИС-ийн Ректорын 2022 оны Б/344 тоот тушаалаар Ахисан түвшний сургуулийн бүтцийг шинэчлэн баталж, Докторын хөтөлбөрийн хэрэгжилтийг 1 менежер, 2 мэргэжилтэн хариуцан ажилладаг байна. Их сургуулийн Захиргаа, хүний нөөцийн алба нь багш, ажилтны хувийн хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн сургалтын болон хөгжлийн хэрэгцээнд нь нийцсэн хөтөлбөр боловсруулан дотоод сүлжээндээ “Мэдлэг тэлэх мэдээллийн сан” нэртэй цэс үүсгэн, сургалтын хэрэглэгдэхүүнийг байршуулан ажиллахын зэрэгцээ суралцах хөгжих нөхцөлийг зохих түвшинд бүрдүүлдэг байна. Мөн M-Hub ажиллуулан заавар зөвлөгөөг өгч ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 3 дугаар зүйлийн 3.8,
- “СЭЗИС-ийн Хүний нөөцийн бодлогын баримт бичиг” -ийн 6, 7.
- Өөрийн үнэлгээний тайлангийн 124-125 дахь тал.

#### **Дүгнэлт:**

- Хэрэгжүүлж буй хөтөлбөрт суралцагчдын тоотой харьцуулахад захиргааны ажилтан (сургалтын менежер 1, мэргэжилтэн 2)-ны ачаалал тэнцвэртэй.

---

<sup>12</sup> <https://ufe.edu.mn/c/76>

- Захиргааны ажилтны ажлын байран дээрээ суралцах, боломжийг зохих түвшинд журамлан хэрэгжилтийг ханган ажилладаг.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

### **6.3. Удирдлагын мэдээллийн систем**

Хөтөлбөрийн удирдлагын шуурхай, оновчтой үйл ажиллагааг хангахад чиглэсэн мэдээлэл цуглуулах, боловсруулах удирдлагын мэдээллийн системтэй байна. Цуглуулсан мэдээлэл, дүн шинжилгээг хөтөлбөрийг сайжруулахад ашигладаг байна.

СЭЗИС нь удирдлагын шуурхай, оновчтой үйл ажиллагааг хангахад чиглэсэн, мэдээлэл цуглуулах, боловсруулах удирдлагын мэдээллийн тогтолцоог бэхжүүлэн ажиллаж буй дээд боловсролын байгууллагын хувьд хэрэгцээтэй мэдээ, мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийх, сургалтын үйл ажиллагааны чанарыг сайжруулах, судалгаанд ашиглах зэрэг үүлэн технологид суурилсан хөгжлийг дэмжин ажилладаг байна. Мэдээллийн системийг хэрэглээгээр нь (Үндсэн систем, дэд систем, дэд бүтэц, олон нийт, хэрэглэгч, байгууллага) гэж ангилан хандах эрх болон зөвшөөрөл олгодог байна.

**Илрэл нотолгоо:**

- “СЭЗИС-ийн Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын баримт бичиг”<sup>13</sup>-ийн 2 дугаар бүлэг.
- “СЭЗИС-ийн Хэрэглэгчийн мэдээллийн системд хандах эрх зохицуулалтын журам”<sup>14</sup>-ийн 2 дугаар бүлэг.
- Өөрийн үнэлгээний тайлангийн 128-131 дэх тал.
- СЭЗИС-ийн мэдээллийн системийн танилцуулга

**Дүгнэлт:**

- Тус сургууль нь удирдлагын мэдээллийн системээрээ элсэлтээс төгсөлт хийх хүртэлх сургалт, судалгаа, мэдээллийн бүх үе шатыг автоматжуулсан.
- Системээр цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хэрэгжүүлж буй хөтөлбөрийг сайжруулахад анхаарч ажилладаг байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

### **6.4. Мэдээллийн ил тод байдал**

Тухайн хөтөлбөрийн танилцуулга, суралцахуйн зорилтот үр дүн, элсэгчид тавих шаардлага, сургалтын төлөвлөгөөний бүтэц, хичээлийн хөтөлбөрүүд, суралцах ачаалал, багц цаг, суралцагчийн үнэлгээний аргачлал зэрэг мэдээллийг багш,

<sup>13</sup> СЭЗИС-ийн Ректорын 2019 оны А/103 тоот тушаалаар баталсан “СЭЗИС-ийн Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын баримт бичиг батлах тухай”.

<sup>14</sup> СЭЗИС-ийн Ректорын 2022 оны А/54 тоот тушаалаар баталсан “СЭЗИС-ийн Хэрэглэгчийн мэдээллийн системд хандах эрх зохицуулалтын журам батлах тухай”.

суралцагчдад нээлттэй хүргэж, цаашид тогтмол шинэчилдэг байна.

СЭЗИС-ийн [www.ufe.edu.mn](http://www.ufe.edu.mn) хуудсанд докторын хөтөлбөрийн<sup>15</sup> танилцуулга, элсэгчид тавих шаардлага, суралцах хугацаа, ачаалал зэрэг хөтөлбөрт оролцогч болон сонирхогч талуудыг мэдээллээр хангахад чиглэсэн мэдээллийг ил тод байршуулсан. Түүнчлэн технологийн эрин үеийн олон нийтийн мэдээллийн суваг (twitter, Instagram.com, linkedin.com, youtube.com)-аар дамжуулан шуурхай хүргэж, тогтмол шинэчилдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- “Докторын сургалтын журам”-ын
- “СЭЗИС-ийн Хэрэглэгчийн мэдээллийн системд хандах эрх зохицуулалтын журам”-ийн 3, 4 дүгээр бүлэг.
- Өөрийн үнэлгээний тайлангийн 131-134 дэх тал.

#### **Онцлог зүйл:**

- Мэдээллийн ил тод байдлыг хангахдаа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (2021)-ийн хэрэгжилтийн хүрээнд “СЭЗИС-ийн Хэрэглэгчийн мэдээллийн системд хандах эрх зохицуулалтын журам”, “СЭЗИС-ийн Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын баримт бичиг”, “СЭЗИС-ийн Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам” -ыг бие даасан хэм хэмжээний хүрээнд батлан мөрдөж байгаа нь сайшаалтай байна.

#### **Дүгнэлт:**

- Хөтөлбөрийн талаарх мэдээллийг олон нийтэд чанар хүртээмжтэй байдлаар хүргэдэг. Мэдээлэлдээ тогтмол шинэчлэл хийж, сонирхогч болон оролцогч талуудын мэдээллийн эрэлтийг судлан үздэг.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ:** Бүрэн хангасан

### **Шалгуур 7. Чанарын баталгаажуулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын тогтолцоотой байна.

#### **7.1. Дотоод чанарын баталгаажуулалт ба хөтөлбөрийн сайжруулалт**

Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүхэлд нь болон үе шат бүрийг, түүнчлэн бүрэлдэхүүн хэсэг (хичээлийн хөтөлбөрүүд, суралцахуйн орчин, багшлахуй ба суралцахуйн үнэлгээ, элсэлт ба төгсөлт, төгсөлтийн ажил эрхлэлт гэх мэт) тус бүрийг байнга хянан үнэлж, тухай бүр сайжруулах чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоотой байна. Чанарын дотоод баталгаажуулалтын бүтэц, үйл явцад бүх талууд оролцдог байна.

#### **Илрэл нотолгоо:**

<sup>15</sup> <https://ufe.edu.mn/c/5/i/135>



- Чанарын баталгаажуулалттай холбоотой нэр бүхий 9 төрлийн эрх зүйн баримт бичиг
- СЭЗИС-ийн PDCA-н тусламжтайгаар чанарыг тасралтгүй сайжруулах зураглал
- СЭЗИС-ийн чанарын дотоод баталгаажуулалтыг хангах, зохион байгуулах төлөвлөгөөний хамрах хүрээ
- СЭЗИС-ийн сургалтын хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын журам
- СЭЗИС-ийн сургалт, судалгааны үйл ажиллагааны чанарт тавих хяналтын зураглал
- Докторын хөтөлбөрийн гарц, үр дүнг үнэлэх үр дүнгийн төлөвлөгөө

#### **Онцлог зүйл:**

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын бодлого, журам, хөтөлбөртэй.
- Сургалт, судалгааны үйл ажиллагааны чанарт тавих хяналт шинжилгээ, үнэлгээний процессийн зураглалын дагуу үйл ажиллагаа нь зохицуулагддаг.

#### **Дүгнэлт:**

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг хангахдаа холбоотой Монгол улсын болон СЭЗИС-ийн холбогдох дүрэм, журмуудаар зохицуулан ажилладаг.
- Сургалтын үйл ажиллагааны чанарыг шинэ элсэгч элсүүлэхээс эхлээд докторын зэрэгтэй төгсөгч болгох хүртэлх үйл явц нь сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, агуулга, сургалтын ажлын зохион байгуулалт, багшийн сонголт, ур чадвар, багшийн хөгжил, сургалтын орчин зэрэг олон хүчин зүйлсээс хамаарч цогцоор нь сайжруулахын тулд сургуулийн эрхэм зорилго, зорилго, алсын хараа, алба нэгжүүдийн зорилго чиглэгдэж, холбогдох дүрэм журмуудад тусгалаа олж байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Зөвлөмж:**

- Дотоод чанарын баталгаажуулалтыг удирдлагаар хангах шинэчилсэн бүтцийг баталж, сургуулийн эрхэм зорилго, хөтөлбөрийн зорилготой уялдуулан системтэйгээр зохион байгуулах

### **7.2. Чанарын хөндлөнгийн үнэлгээ ба магадлан итгэмжлэл**

Жил бүр хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурын дагуу өөрийн үнэлгээ хийж, үндэсний болон олон улсын нийтлэг жишигт хүрэхийг эрмэлзэж ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Байгууллагын болон хөтөлбөрийн олон улсын, үндэсний хэмжээний магадлан итгэмжлэл хийлгэсэн гэрчилгээ

**Онцлог зүйл:**

- Байгууллагын магадлан итгэмжлэлд 2000, 2005, 2019 онуудад БМИҮЗ-ийн үндэсний хэмжээнд 3 дах удаагаа магадлан итгэмжлэгдсэн, ACBSP байгууллагаар 2022 онд 2 дахь удаагаа олон улсын түвшинд магадлан итгэмжлэл хийлгэсэн.

**Дүгнэлт:**

- Хэрэгжиж буй бакалаврын болон магистрын хөтөлбөрүүдийг үе шат дараатайгаар үндэсний болон олон улсын магадлан итгэмжлэл хийлгэсэн.
- Байгууллагын стандарттай, түүнийг хэрэгжүүлэх механизм бүрдсэн нь давуу талтай.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ:** Бүрэн хангасан

### ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Докторын хөтөлбөрийн зорилго, агуулга	3	2		
2	Докторын хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт	5			
3	Докторантын суралцахуйн үнэлгээ, хөгжил	8			
4	Багшлах бүрэлдэхүүн	3	1		
5	Нөөц ба санхүүжилт	3			
6	Удирдлага ба мэдээллийн систем	4			
7	Чанарын баталгаажуулалт	2			
<b>Дүгнэлт</b>		<b>БҮРЭН ХАНГАСАН</b>			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг “Бизнес удирдлага” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн Докторын

хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Бизнес, удирдлагын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг ..... //

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....//

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... //

## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Докторын хөтөлбөрийн зорилго, агуулга	<ul style="list-style-type: none"> <li>- Хичээл сонголтыг докторын хөтөлбөрийг магистрын хөтөлбөртэй уялдуулах замаар буюу магистр болон докторын түвшинд аль алинд нь үзэх боломжтой хичээлүүдийг бий болгох замаар өргөжүүлэх</li> <li>- Энтрепренёр их сургууль болон хөгжихөд шаардлагатай судалгааны дэд бүтцийг хөгжүүлэх, стратегийн зорилгодоо нийцсэн судалгааны чиглэлүүдийг оновчтой тодорхойлон гаргах асуудалд анхаарах</li> <li>- Сургалтын хөтөлбөрт тусгасан хичээлийн агуулга, хичээл сонгох боломжийг докторын оюутны судалгааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өргөжүүлэх</li> </ul>
Шалгуур 2. Докторын хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт	<ul style="list-style-type: none"> <li>- Шинэ, сайн элсэгчдийг татахад бодлогоор дэмжих</li> <li>- Докторантууд руу чиглэсэн сургалтын арга зүйгээ илүү орчин үеийн чиг хандлагатай болгох</li> <li>- Докторантын гүйцэтгэж буй судалгааны ажил болон судалж буй хичээлүүдийн уялдаа холбоог анхаарах</li> </ul>
Шалгуур 3. Докторантын суралцахуйн үнэлгээ, хөгжил	<ul style="list-style-type: none"> <li>- Докторантууд нь одоогоор зөвхөн докторын хөтөлбөрт нэр заасан хичээлийг судлаж байгаа бөгөөд цаашид ахисан түвшний хөтөлбөр (СЭЗИС-ийн магистрын хөтөлбөр, бусад ижил түвшний хөтөлбөр хэрэгжүүлж буй их сургуулиудын хөтөлбөрөөс судалгааны сэдэв чиглэлд дэмжлэг үзүүлэхүйц хичээл)-өөс сонгон суралцах боломжийг тодорхой болгох</li> <li>- Гадаадын болон дотоодын байгууллагын тэтгэлэг, дэмжлэгээр суралцах докторантын тоог нэмэгдүүлэхэд анхаарал хандуулах, судалгааны бүтээлийг нь эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах боломжийг цаашид эрэлхийлэх</li> </ul>
Шалгуур 4. Багшлах бүрэлдэхүүн	<ul style="list-style-type: none"> <li>- Бүх багш нараа докторын зэрэг хамгаалуулах замаар зарим багш нарт, ялангуяа ахисан түвшинд багшилж байгаа багш нарын ажлын ачааллыг бууруулах</li> <li>- Удирдагч багшийн удирдлага дор докторантын</li> </ul>

	<p>докторантын хийж гүйцэтгэх судалгааг дэмжих, өндөр түвшний судалгааг дэмжихэд чиглэсэн зохицуулалт, санхүүжилтийн олон эх үүсвэрийг бий болгох тал дээр анхаарч ажиллах</p> <ul style="list-style-type: none"> <li>- Багш нарын, ялангуяа докторын судалгааг удирддаг багш нарын гүйцэтгэх судалгаа шинжилгээний ажлын цар хүрээг өргөжүүлэх, түүнд докторын оюутнуудаа татан оролцуулах</li> <li>- Судалгааны багт орж чадаагүй багш нарыг судалгааны ажилд хэрхэн татан оролцуулах, тэдний судалгааг хэрхэн санхүүжүүлэх, багш нарын академик эрх чөлөөг хэрхэн хангах зэрэг асуудалд анхаарах</li> </ul>
Шалгуур 5. Нөөц ба санхүүжилт	<ul style="list-style-type: none"> <li>- Нийт сурах бичгийн тоо хэмжээ хэмжээнд эзлэх докторын хөтөлбөрт хамаарах номын фондыг сайжруулах</li> <li>- Хөтөлбөрийн санхүүжилтыг бусад эх үүсвэрээс олох нөхцлийг бүрдүүлэх</li> </ul>
Шалгуур 6. Удирдлага ба мэдээллийн систем	-
Шалгуур 7. Чанарын баталгаажуулалт	<ul style="list-style-type: none"> <li>- Дотоод чанарын баталгаажуулалтыг удирдлагаар хангах шинэчилсэн бүтцийг баталж, сургуулийн эрхэм зорилго, хөтөлбөрийн зорилготой уялдуулан системтэйгээр зохион байгуулах</li> </ul>
<b>Шалгуур</b>	<b>Шаардлага</b>
Шалгуур 1.1 Хөтөлбөрийн боловсруулалт	<ul style="list-style-type: none"> <li>- Докторын түвшний судалгааг дэмжих болон санхүүжүүлэхэд зарцуулж буй зардлаа нэмэгдүүлэх, ялангуяа олон улсын түвшний бүтээлүүдийн үнэлгээг сайжруулах, багш оюутны хамтарсан судалгааг дэмжсэн дүрэм журмуудыг боловсруулах замаар олон улсын ранкаа дээшлүүлэх</li> </ul>
Шалгуур 1.3 Хөтөлбөрийн агуулга	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөртөө докторантын судалгаа шинжилгээний ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн өөрчлөлтүүдийг хийх</li> </ul>
Шалгуур 4.1 Багшийн нөөц	<ul style="list-style-type: none"> <li>- Докторын сургалтад заах хичээл, багш нарын тоог олшруулах</li> </ul>

#### IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

##### Суралцагчдын нэрс

1	Э.Тамир	3	80100608
2	Цэцэнтан	4	86986193
3	Цэлмэг	4	80683934
4	Б.Тулга	3	99135789
5	Г.Цэлмэг	2	91117341
6	Ж.Өлзийбаяр	5 дээш	91995005
7	Б.Дэлгэрсайхан	5 дээш	99051141
8	А.Одгэрэл	5 дээш	99059261
9	Д.Мөнгөнтуул	5 дээш	99095491
10	П.Баяржаргал	1	99125052
11	Б.Үрэлцэцэг	4	99103328
12	Б.Ганшагай	4	90908992
13	Т.Пүрэвхатан	4	99071745
14	Ц.Азбаяр	4	99998666
15	Б.Мөнхжаргал	3	99500208
16	П.Элбэгзаяа	2	99049292
17	Б.Түвшинтөгс	5 дээш	99058815
18	Т.Алтангэрэл	2	99051108

##### Ажил олгогчдын нэрс

1	С.Мөнхбаяр	СЭЗИС, ректор	99911119
2	Б.Мөнхзаяа	Бакалаврын сургалт, судалгаа хариуцсан проректор	95964554
3	Г.Батхуяг	Ахисан түвшний судалгаа, сургалт хариуцсан проректор	80225152
4	Б.Бүжинлхам	Ахисан түвшний сургуулийн захирал	99114441
5	Г.Намужин	Санхүү удирдлагын тэнхимийн эрхлэгч	88663913
6	Б.Амарсанаа	Бизнесийн удирдлагын тэнхимийн эрхлэгч	95118089

##### Төгсөгчдийн нэрс

1	Б.Мөнхзаяа	2013	Бакалаврын сургалт, судалгаа хариуцсан проректор	95964554
2	З.Оюунцацрал	2013	Ахисан түвшний профессор	99045052
3	Д.Больтогтох	2013	СУТ-ийн профессор	99098575
4	С.Бямбахорлоо	2016	Эдийн засаг санхүү хариуцсан проректор	99099435
5	Т.Туяа	2019	СУТ-ийн дэд профессор	99008205
6	Д.Түвшинжаргал	2020	Экономиксийн тэнхимийн эрхлэгч	88000094

7	Г.Гантулга	2017	Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн эрхлэгч	99092354
8	Б.Энхтуул	2018	МУИС ХШУИС МКУТэнхимд дэд профессор	86064644
9	Г.Уянга	2015	МУИС Бизнесийн сургууль Менежментийн тэнхимийн ахлах багш	90901078
10	Т.Лагнай	2016	ХУДС-ийн профессор	91919175
11	Ж.Танан	2020		99112973
12	Д.Нямдорж	2016		99117994
13	Б.Цогтбаяр	2016	СЭЗИС-ийн Олон улсын аялал жуулчлалын сургалт, судалгааны институт	88014840

### Уулзалтанд оролцсон багш нарын мэдээлэл

1	Г.Батхуяг	Доктор, профессор	Ахисан түвшний судалгаа, сургалт хариуцсан проректор	Үндсэн
2	Д.Гэрэлмаа	Доктор, профессор	Ахисан түвшний профессор	Үндсэн
3	С.Бямбахорлоо	Доктор, профессор	Эдийн засаг санхүү хариуцсан проректор	Үндсэн
4	Д.Түвшинжаргал	Доктор, дэд профессор	Тэнхимийн эрхлэгч	Үндсэн
5	Т.Оюунгэрэл	Доктор, дэд профессор	БУТ-ийн дэд профессор	Үндсэн
6	Ц.Батсүх	Доктор, профессор	Экономиксийн тэнхимийн профессор	Үндсэн
7	Б.Энхмаа	Доктор, ахлах багш	ГСИ ахлах багш	Үндсэн
8	З.Оюунцацрал	Доктор, профессор	Ахисан түвшний профессор	Үндсэн
9	Д.Болормаа	Доктор, профессор	Ахисан түвшний профессор	Үндсэн
10	Т.Цэнд-Аюуш	Доктор, профессор	Ахисан түвшний профессор	Үндсэн
11	Kim Young Rae	Доктор	Ахисан түвшний профессор	Үндсэн
12	Б.Болорсүвд	Доктор, дэд профессор	Экономиксийн тэнхимийн дэд профессор	Үндсэн

## V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



### САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ

Эхэстэйшны прорах чиглэл 5,  
Бэлчээр дүүрэг, Улаанбаатар хот, 13381 ш/о-49,  
Утас: 7000 8085, Цахим суудал: info@ufe.edu.mn,  
Цахим хуудас: www.ufe.edu.mn

2023 / 06 / 19 № 6 / 638  
тантай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

### БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

#### Шинжээчийн дүгнэлтэд хариу хүргүүлэх тухай

Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн “Бизнесийн удирдлага” /041301/,  
“Менежмент” /041303/ докторын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланд хөндлөнгийн  
үнэлгээ хийсэн шинжээчийн багийн тайланг хүлээн авч танилцлаа.

Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас Шалгуур 4.1-г дарвах тодруулгыг  
хүргүүлж байна. Үүнд: Дээд боловсролын түвшинд суралцагч, багшлах боловсон  
хүчний харьцааг олон улсын дунджаар 1:18 гэж тодорхойлсны дагуу бид нэг жилд 12-20  
докторант элсүүлэн суралцуулахыг тооцоолж ажилладаг. Докторын хөтөлбөрт хичээл  
ордог нэг багшид ногдох оюутны тоог харьцангуй цөөн байгаадаг нь хөтөлбөрийн  
төлөвлөлт, хэрэгжилт, чанар, хүртээмж, эхсэгчийн тоо, суралцагч нэг бүрд хүрч ажиллах  
боломж зэрэгтэй уялдсан. Түүнчлэн докторын хөтөлбөрт нэг багшийг хичээлийн жилд  
гурваас илүүгүй хичээл оруулахыг төлөвлөж, багшийн нөөцөө бүрдүүлэн ажилладаг  
болно. Энэхүү тодруулгыг харгалзаж үзэхийг шинжээчийн багийнхнаас хүсэж байна.

Бид цаашид шинжээчийн багийн өгсөн зөвлөмжийн дагуу тус хөтөлбөрүүдийг  
улам чанартай хэрэгжүүлэхэд анхааран ажиллах болно.

РЕКТОР



Б.МОНХБАЯР